



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ЖДҮГ НЬ ЖДҮҮ ЭРХЛЭГЧ НАРТ САНГААС ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ОЛГОЖ ЧАДААГҮЙ, ХААК ТӨХХК-ИАС ХАА-Н ДЭМЖЛЭГ АВСАН 6387 ЗЭЭЛДЭГЧ БУЮУ 78.7 ХУВЬ НЬ 6-ААС ДЭЭШ ЖИЛЭЭР ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ, ЗБДС НЬ ХХААХҮЯ-НЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХГҮЙ ЗАРИМ САЛБАРУУДЫН ЗЭЭЛД ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТ ГАРГАЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУД БОЛОН “ХӨДӨӨ, АЖ АХУЙН КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/24-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Д.Энхболд
Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn
Аудитын менежер Д.Баттулга
Утас: 261639, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn
Ахлах аудитор З.Мөнхбаяр
Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn
Аудитор Т.Төмөрбаатар
Цахим хаяг: tumurbaatart@audit.gov.mn
Т.Шүрэнцэцэг
Цахим хаяг: shurentstetsegt@audit.gov.mn
Л.Номин
Цахим хаяг: nominl@audit.gov.mn
А.Тэргэл
Цахим хаяг: tergela@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БНБУ	Бүгд Найрамдах Беларусь Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗБДСтХ	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮҮ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ
ЖДҮҮДтХ	Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль
ЖДҮХ	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
МАОЭНХ	Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МУХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
НББтХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
СБХ	Санхүүгийн бодлогын хэлтэс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХААБГ	Санхүү, худалдан авах ажиллагааны бодлогын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБСТЗГ	Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй
“ХААК” ТӨХХК	“Хөдөө аж ахуйн корпораци” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХТАХ	Хууль, тусгай активын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө, аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө, аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүнтэй эсэх;*
- *“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;*
- *Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа, хэрэгжилт, зарцуулалт үр дүнтэй эсэх;*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад шалгагдагч байгууллагаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Зээлийн батлан даалтын сан болон тус газруудаас 2023, 2024 онд зээл авсан иргэн, ААН болон бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- *Төрийн аудитын тухай хууль;*
- *Төсвийн тухай хууль;*
- *Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;*
- *Зээлийн мэдээллийн тухай хууль;*
- *Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль;*
- *УИХ-ын болон ЗГ-ын холбогдох тогтоол, шийдвэрүүд.*

Аудитын багийн бүрэлдэхүүн

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Баттулга хэрэгжүүлж, ахлах аудитор З.Мөнхбаяр, аудитор Т.Төмөрбаатар, Т.Шүрэнцэцэг, А.Тэргэл, Л.Номин нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитад шалгагдагч байгууллагаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Зээлийн батлан даалтын сан болон тус газруудаас 2023, 2024 онд зээл авсан иргэн, ААН болон бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

Ерөнхий мэдээлэл:

Жижиг, дунд үйлдвэрийн газар

ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна.”, Мөн ЖДҮҮД тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан байна” гэж тус тус заасан байна.

ЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-ыг байгуулан ЖДҮХ сангийн ажлын албыг татан буулгаж, холбогдох чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, эд хөрөнгийн хамт ЖДҮГ-т шилжүүлсэн байна. ЖДҮХ сангаас 2009-2024 онд нийт 370,110.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1747 иргэн, ААН-д олгосон байна.

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК

ЗГ-ын 2021 оны 394 дүгээр “Төрийн өмчит компани байгуулах тухай” тогтоолоор “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан байна. ТӨБЗГ-ын 2023 оны 505 дугаар “Хөрөнгө өр төлбөр балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/553 дугаар “Авлага, өр төлбөр балансаас балансад шилжүүлэх тухай” тушаал зэргийг үндэслэн Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны үйл ажиллагааг 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д бүрэн шилжүүлсэн байна.

“ХААК” ТӨХХК-ийн 2005 оноос хойш ХАА-н салбарыг дэмжихээр олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас үзэхэд нийтдээ 157,669.8 сая төгрөгийг 7898 иргэн ААН-д олгосон байна.

Зээлийн батлан даалтын сан

Зээлийн батлан даалтын сангийн хуулийг УИХ-ын 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан. Уг хуульд заасны дагуу 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн үүсгэн байгуулагчдын анхны хуралдаанаар үүсгэн байгуулсан.

ЗБДС-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу сангийн удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл бөгөөд тус Удирдах зөвлөл 9 гишүүнтэй, даргаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд ЗБДС-ийн эцсийн өмчлөгч нь ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бүртгэлтэй байна. Тус сан нь 5 хувьцаа эзэмшигчтэй байна. Үүнд:

- Сангийн яам
- Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
- Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/
- Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- Хөдөлмөрийн яам /хуучин нэрээр/

БҮЛЭГ 1. ЖДҮХ САНГААС ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН 107.4 ТЭРБУМ ТӨГРӨГ НЬ НАЙДВАРГҮЙ АВЛАГА БОЛОХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Дараах нөхцөлийг хангасан аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамааруулна” гэж тусгасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. ЖДҮҮ эрхлэгчдийн ангилал

Ангилал	Ажилтны тоо	Борлуулалтын орлогын хэмжээ	Зээл олгох хэмжээ
Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл	0-300.0 сая	300.0 сая төгрөг хүртэл
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50 хүртэл	300.0-1,000.0 сая	1,000.0 сая төгрөг хүртэл
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-200 хүртэл	1,000.0-2,500.0 сая	2,500.0 сая төгрөг хүртэл

ЖДҮХ сангийн 2023-2024 оны эх үүсвэрийн 91 хувийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос бүрдүүлж байна.

ЖДҮХ сангийн санхүүжилтэд “Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөл”-д 204,000.0 сая төгрөг, “Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл”-д 113,002.0 сая төгрөгийн санал өгсөн боловч Улсын төсвийн хөрөнгийг батлаагүй байна. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-тэй холбоотойгоор 1,462.9 сая төгрөгийг 2024 онд улсын төсөвт батлагдсан байна.

Хүснэгт 2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023, 2024 оны эх үүсвэрийн мэдээлэл

№	Эх үүсвэр	/сая.төг/	
		2023 он	2024 он
1	Улсын төсвийн хөрөнгө	-	1,463.0
2	Зээлийн эргэн төлөлт	45,546.1	48,954.0
3	Зээлийн хүүгийн орлого	3,017.6	2,694.8
4	Орон нутгийн төсвийн санхүүжилт	5,800.0	4,200.0
Нийт		54,363.7	57,311.8

Холбогдох журмын дагуу арилжааны банкаар дамжуулан жижиг болон дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй байна.

ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.1¹-д сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан ЖДҮҮ эрхлэгчдэд зээл олгохоор зохицуулсан ч тус журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ЖДҮГ 2023-2024 онд нийт 545 аж ахуйн нэгжид **бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн** ангиллаар 74,042.9 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Харин жижиг болон дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд арилжааны банкаар дамжуулан зээл олгоогүй байна.

Хүснэгт 3. ЖДҮХ сангаас 2023, 2024 онд зээл авсан ААН-үүдийн талаарх мэдээлэл

Байршил	2023 он				2024 он			
	Хүсэлт ирүүлсэн	Зээл авсан	Мөнгөн дүн	Хувь	Хүсэлт ирүүлсэн	Зээл авсан	Мөнгөн дүн	Хувь
Орон нутаг	604	223	27,324.1	77.1	520	216	26,863.6	69.6
Нийслэл	216	42	8,112.3	22.9	322	64	11,742.9	30.4
Нийт	820	265	35,436.4		842	280	38,606.5	

ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн

¹ 3.1. Зээлийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу Сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан олгоно.

төлүүлэх, хяналт тавих журам”-ын журмын 10 дугаар зүйлийн 10.5-д² гэж заасан боловч төсөл хүлээн авснаас хойш сонгон шалгаруулалтын үе шатны үнэлгээ хийх нарийвчилсан хугацааг тусгаагүй байна.



ЖДҮХ сангийн нийт зээлийн үлдэгдлийн 57.7 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

ЖДҮХ сангаас 2009-2024 оны нийт 370,110.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1747 зээлдэгчид олгожээ. Үүнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2019 оны А-155/134 дүгээр тушаалын хавсралтаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1³-т заасан ангиллын дагуу 78,641.3 сая төгрөгийн 739 зээл хэвийн, 3,270.1 сая төгрөгийн 36 зээл хэвийн бус, 2,722.5 сая төгрөгийн 40 зээл эргэлзээтэй, 4,574.7 сая төгрөгийн 55 зээл хугацаа хэтэрсэн, 96,820.1 сая төгрөгийн 369 зээл муу ангилалд бүртгэсэн байна.

Хүснэгт 4. Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн мэдээлэл (2009-2024 он)

													/сая.төг/
№	Он	Иргэн, ААН /тоо/	Үндсэн зээлийн бодит үлдэгдэл	Ангилал									
				Хэвийн /15-30 хоног/		Анхаарал хандуулах /90-аас бага хоног/		Хэвийн бус /91-180 хоног/		Эргэлзээтэй /181-360 хоног/		Муу /361-ээс дээш хоног/	
1	2009	9	192.3	-	-	-	-	-	-	-	-	9	192.4
2	2010	5	86.3	-	-	-	-	-	-	-	-	5	86.3
3	2011	18	1,046.9	-	-	-	-	-	-	-	-	18	1,046.9
4	2012	2	27.8	-	-	-	-	-	-	-	-	2	27.8
5	2013	6	4,353.8	-	-	-	-	-	-	-	-	6	4,353.8
6	2014	15	8,895.0	-	-	-	-	-	-	-	-	15	8,895.0
8	2016	22	14,379.5	-	-	-	-	-	-	-	-	22	14,379.5
9	2017	75	22,661.8	-	-	-	-	-	-	-	-	75	22,661.8
10	2018	93	31,887.0	-	-	-	-	-	-	-	-	93	31,887.0
11	2019	93	7,767.7	29	819.9	3	256.7	2	2.2	9	218.6	50	6,470.4
12	2020	192	7,501.8	101	2,475.1	17	609.2	15	540.4	16	591.0	43	3,286.1
13	2021	12	458.2	6	238.4	5	139.8					1	80.0
14	2022	154	14,941.2	107	9,676.5	10	824.8	4	402.9	11	1,245.0	22	2,792.0
15	2023	263	33,257.4	218	27,455.4	18	2,148.3	15	2,324.6	4	668.0	8	661.2
16	2024	280	38,571.9	278	37,976.0	2	596.0	-	-	-	-	-	-
Нийт		1239	186,028.6	739	78,641.3	55	4,574.7	36	3,270.1	40	2,722.5	369	96,820.1

Эх сурвалж: ЖДҮГ-Монголбанкны зээлийн мэдээллийн сан

² “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, тухайн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна”

³ 2.1.1.1.Хэвийн, 2.1.1.2.Анхаарал хандуулах; 2.1.1.3.Чанаргүй ангилал, үүнээс: 2.1.1.3.а.Хэвийн бус; 2.1.1.3.б.Эргэлзээтэй; 2.1.1.3.в.Муу.

БҮЛЭГ 2. УЛААН БУУДАЙН БОЛОН БАГА ОВРЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ОЛГОСОН ДЭМЖЛЭГЭЭС 140,627.8 САЯ ТӨГРӨГ БУЮУ 80.4 ХУВЬ НЬ ГЭРЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

“ХААК” ТӨХХК-ийн ТУЗ бизнес төлөвлөгөөнд зорилтот түвшнийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

“ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар 2023 оны бизнес төлөвлөгөөг, харин 2024 оны бизнес төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан боловч 9 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 5. Бизнес төлөвлөгөөний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он			2024 он		
			Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь
1.	Улаан буудайн нөөц бүрдүүлэлт	Тонн	60,200.0	44,135.5	73.3	81,700.0	57,667.2	70.5
	Хүнсний улаан буудай	Тонн	55,200.0	28,775.4	52.1	73,700.0	49,528.5	67.2
	Үрийн буудай	Тонн	5,000.0	4,778.3	95.5	8,000.0	7,756.2	96.9
	Тэжээлийн буудай	Тонн		10,581.8			382.5	
2.	Авлага барагдуулалтын талаар	Сая.төг	8,668.8	16,183.1	186.7	39,635.0	42,354.0	106.8
3.	Зээл, санхүүгийн эргэн төлөлт	Сая.төг	20,800.0	26,600.0	127.9	26,336.9	7,711.2	29.2
4.	Байгууллагын орлого	Сая.төг	5,585.1	19,000.0	340.1	99,981.7	56,603.3	56.6
5.	Үйл ажиллагааны зардал	Сая.төг	9,131.1	6,435.9	67.8	103,333.8	66,418.2	62.4
	Үндсэн үйл ажиллагааны зардал	Сая.төг	9,036.0	6,400.0	70.8	99,533.8	64,312.9	64.6
	Хөрөнгө оруулалт	Сая.төг	101.1	35.9	35.5	3,800.0	2,105.3	55.4
6.	Бараа ажил үйлчилгээ худалдан авах	Сая.төг	3,469.1	2,103.3	60.6	6,862.2	1,794.5	26.1

Эх сурвалж: “ХААК” ТӨХХК

Санхүүгийн тайлангаар иргэн, ААН-ээс авах авлага 2023 онд 213,959.2 сая төгрөг 2024 онд 194,250.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсны 11.8 хувийг барагдуулахаар тооцсон нь үр дүнтэй төлөвлөлт болж чадаагүй байна.

Монгол Улсын стандарт хүнсний буудайн техникийн шаардлага MNS 0097:2010-д заасан соёолсон тариа зөөлөн буудайн физик химийн үзүүлэлт 2.0 хувь байхыг “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 15 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын 2023 оны А/81 дүгээр “Хүлээн авах түр журамд өөрчлөлт оруулах чиглэл өгөх тухай” тушаалаар соёолсон тариан дээд хэмжээг 3,5 хувь болгон өөрчилж 151 ААН-ээс 5,967.8 сая төгрөгийн 6,486.7 тонн улаан буудайг хүлээн авсан байна.

“ХААК” ТӨХХК БНХАУ-ын ЗГ-ын дамжуулан зээл, БНБУ техникийн зээл, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт үлдэгдэл 226,052.5 сая төгрөг, ханшийн зөрүүний гарз 50,223.7 сая төгрөг төлсөн байна.

Хүснэгт 6. “ХААК” ТӨХХК-ийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Он	Зорилтот түвшний төлөвлөгөө			Зорилтот түвшний гүйцэтгэл		
	Орлого	Зарлага	Ашиг /алдагдал	Орлого	Зарлага	Ашиг /алдагдал
2023	5,585.1	8,376.1	(2,791.0)	10,527.1	15,337.6	(4,810.4)
2024	99,981.7	99,801.4	180.3	56,603.3	64,312.9	(7,709.9)

2023, 2024 онд дараалан зорилтот түвшний эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Тухайлбал, 2023 онд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д 2,500.0 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн, 2023 онд худалдан авсан хүнсний улаан буудайн төлбөрт 4,600.0 сая төгрөгийг шилжүүлсэн, 2024 онд орлогын төлөвлөгөө 43.4 хувиар тасарсан нь дотоодын гурилын үйлдвэрүүдийн хүнсний улаан буудайн худалдан авалт буурсан, зардлын гүйцэтгэл 35.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь хүнсний улаан буудайн борлуулалт

төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурсан зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

ХАА-н дэмжлэг авсан 6387 зээлдэгч 78.7 хувь нь 6-аас дээш жилээр зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

ХАА-г дэмжихээр олгосон 174,986.5 сая төгрөгийн 8523 зээлээс 34,358.7 сая төгрөгийн 413 зээл хугацаандаа, 140,627.8 сая төгрөгийн 8110 зээл хугацаа хэтэрсэн байна.

Хүснэгт 7. ХАА-г дэмжих чиглэлээр олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн мэдээлэл /сая.төг/

№	Хугацаа хэтэрсэн жил	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	1-2 жил	1223	43,707.9
2	3-5 жил	500	12,108.4
3	6-9 жил	1539	38,617.4
4	10-аас дээш жил	4848	46,194.1
Нийт		8110	140,627.8

Эх сурвалж: "ХААК" ТӨХХК

Эдгээрээс 3-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн зээлтэй 96,919.9 сая төгрөгийн 6887 зээлдэгч 68.9 хувийг эзэлж байгаа нь зээлийн авлагууд барагдахгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.

ХАА-н чиглэлээр олгосон үр буудай болон бага оврын тоног төхөөрөмжийн зээлийг 1014 иргэн, ААН-д 2-10 удаа олгосон байна.

Хүснэгт 8. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл (2-10 удаа)

№	Зээл авсан тоо	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	2-4	940	49,335.5
2	5-6	63	21,077.3
3	7-10	11	4,189.8
Нийт		1014	74,602.6

Эх сурвалж: "ХААК" ТӨХХК Санхүүгийн тайлан авлагын дэлгэрэнгүй

БҮЛЭГ 3. ЗБДС 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР 14,032 ЗЭЭЛДЭГЧИД 402,577.9 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛД БАТЛАН ДААЛТ ГАРГАСАН БАЙНА.

ЗБДС-ийн нийт батлан даалтын 72.1 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт эзэлж байна.

3.1.1 ЗБДС 2013-2024 оны хооронд үндсэн батлан даалт, Ипотекийн зээлийн батлан даалт, Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтад нийт 402,577.9 сая төгрөгийн 14032 зээлдэгчийн зээлийг батлан даасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Батлан даалгуулсан зээлдэгчийн тоо болон хөрөнгийн хэмжээ

№	Төрөл	Зээлдэгчийн тоо	Зээлийн дүн	Батлан даалтын дүн	Хувь
1	Үндсэн батлан даалт	746	191,143.1	85,774.4	21.3
2	Ипотекийн зээлийн батлан даалт	1309	140,117.7	26,463.2	6.6
3	Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт	11977	394,496.8	290,340.3	72.1
Нийт		14032	725,757.6	402,577.9	100.0

Эх сурвалж: ЗБДС

3.2 ЗБДС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр тусгасан ба нийт орлогын 91.5 хувийг хадгаламжийн хүүгийн орлого эзэлж байна.

3.2.1 ЗБДС-ийн нийт хөрөнгө бүрдүүлэлтийн 83.4 хувийг Хадгаламжийн даатгалын корпорацаас, улсын төсвөөс 8.3 хувь, хөрөнгө оруулагч, хандивлагчдаас 0.1 хувь, батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжаас 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10. Өөрийн хөрөнгийн бүрдүүлэлтийн байдал

			/сая төгрөг/
№	Санхүүжилтийн эх үүсвэр	Олгосон санхүүжилт	Хувь
1	Улсын төсвөөс	5,000.0	8.3
2	Хадгаламжийн даатгалын корпорац	50,000.0	83.4
2	Хөрөнгө оруулагч, хандивлагч	40.0	0.1
3	Батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж	4,960.0	8.2
Өөрийн хөрөнгийн нийт дүн		60,000.0	100

Эх үүсвэр: ЗБДС

3.2.2 Тус сан нь Хадгаламжийн даатгалын корпорацтай 2021 онд байгуулсан 12/02-02 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэрээ”-нд заасны дагуу эргэн төлөлт хийж байна.

3.2.3 ЗБДС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу 2023-2024 оны үйл ажиллагааны орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна.

Хүснэгт 11. ЗБДС-ийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

							/сая төгрөг/
№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Төлөв.	Гүйц.	Хувь	Төлөв	Гүйц	Хувь
1	Батлан даалтын шимтгэлийн орлого	787.4	864.2	109.7	5,600.0	6,675.6	119.2
2	Хураамжийн орлого	11.4	9.8	86.1	20.0	21.6	108.3
3	Хадгаламжийн хүүгийн орлого	10,384.8	10,934.2	105.3	21,437.1	19,839.4	92.5
4	Үйл ажиллагааны бусад орлого	131.8	137.5	104.3	-	-	-
Нийт дүн		11,315.3	11,945.7	105.6	27,057.1	26,536.6	98.1

Эх сурвалж: ЗБДС

ЗБДС-ийн 2023 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 11,315.3 сая төгрөг байсан ба бодит гүйцэтгэл 11,945.7 сая төгрөг буюу 5.6 хувиар давуулан биелүүлсэн байна. ЗБДС-ийн 2023-2024 оны нийт орлого хадгаламжийн хүүгийн орлого 91.5 хувийг хүүгийн орлого эзэлж байна.

СЗХ-ноос ЗБДС-ийн үйл ажиллагаанд 2023, 2024 онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

ЗБДС-тай холбоотой үйл ажиллагаа нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7⁴-д заасны дагуу санхүүгийн үйлчилгээнд хамаардаг бөгөөд тус байгууллагад хяналт тавихтай холбоотой харилцааг СЗХ-ны 2019 оны 46 дугаартай “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-аар зохицуулдаг.

Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.1⁵, 4.2⁶-д заасны дагуу сангийн үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг жил бүр хийхээр журамласан боловч СЗХ-оос 2023, 2024 онд хяналт хэрэгжүүлээгүй байна. Цаашид журмын хэрэгжилтийг биелүүлж хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Аудитаар зөвлөмж хүргүүлэв.

⁴ 3.1.Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна: 3.1.7.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;

⁵ 4.1.Сангийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлнэ.

⁶ 4.2.Газар дээрх хяналт, шалгалт нь хамрах хүрээнээс хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийгдэнэ. Хорооны даргын томилсон ажлын хэсэг, баталсан удирдамжийн дагуу жил бүр газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

1. ЖДҮГ нь стратеги төлөвлөгөөгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1⁷, ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1⁸ дэх заалтын дагуу ЖДҮГ нь стратеги төлөвлөгөө батлуулаагүй үйл ажиллагаа явуулж байна.
2. ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг батлахдаа тухайн жилийн зээлийн хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөх болон зээлийн хугацааг тогтоосон тооцоолол тодорхойгүй байна.
3. ХХААХҮ-ийн сайдын баталсан тухайн жилийн хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлд тусгаагүй ангиллаар 25 ААН-д 2,828.9 сая төгрөгийн зээл олгосон нь ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/37, 2024 оны А/28 дугаар “Хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл” баталсан тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4. ХХААХҮЯ-ны дотоод хяналт шалгалтын газраас ЖДҮГ-ын үйл ажиллагаа, ЖДҮХС -аас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН-н зээлийн эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй байна. Үүнээс шалтгаалж нийт зээлд эзлэх найдваргүй зээлдэгчийн тоо өссөн байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газар

1. ЗГ-ын 2020 оны 49 дүгээр “Агентлаг байгуулах тухай” тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулж, ЖДҮХ сангийн ажлын албыг татан буулган, холбогдох чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, эд хөрөнгийн хамт уг газарт шилжүүлсэн байна
2. ЖДҮХ сангийн эх үүсвэрт 2023, 2024 онд нийт 111,677.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бичил ангиллаар 74,043.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 545 ЖДҮҮ эрхлэгчдэд олгосон байна. Харин тус сангаас жижиг болон дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй нь тэгш хүртээмжтэй зарчмыг баримталж ажиллаагүй байна.
3. Төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хороо болон нарийвчилсан үнэлгээ хийсэн ажлын хэсэг зарим төсөл сонгон шалгаруулах үе шат бүрд зээл хүсэгчээс ирүүлсэн баримт материалыг бүрэн нягтлан шалгаагүй, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх санхүүгийн чадамжийг бодитой үнэлээгүй байна. Төсөл сонгон шалгаруулах үнэлгээ хийх журамд төсөл хүлээн авснаас хойш үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, гэрээ байгуулах хугацааг тодорхой тусгаагүй байгаа нь хяналтын тогтолцоогүйг харуулж байна.
4. ЖДҮХ сангаас 2023, 2024 онд зарим ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаагүй чиглэлээр 3,987.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 25 ААН-д олгосон нь сангийн үндсэн зорилгод нийцэхгүй байна.
5. ЖДҮХ сангаас 2009-2024 онд 370,110.2 сая төгрөгийн зээл олгосноос 50.3 хувь буюу 186,028.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. ЖДҮГ-аас авлагыг бууруулах талаар арга хэмжээ авч ажилласан ч үр дүн хангалтгүй байна.

⁷ 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

⁸ 2.1. Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК

1. Засгийн газрын 2021 оны 394 дүгээр “Төрийн өмчит компани байгуулах тухай” тогтоолоор “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. ЗГ-ын 2023 оны 269 дүгээр Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгаж “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д шилжүүлсэн байна.
2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан улаан буудайн нөөц бүрдүүлэлт 2023 онд 73.3 хувь, 2024 онд 70.5 хувьтай төлөвлөгөө бүрэн биелэгдээгүй нь хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэлт буурсан, элеваторын буюу нөөц савны багтаамжаас шалтгаалсан байна.
3. Санхүүгийн тайланд бүртгэлтэй иргэн, ААН-ээс авах авлага 2023 онд 213,959.2 сая төгрөг 2024 онд 194,250.3 сая төгрөг байгаагаас зөвхөн 11.8 хувийг нийт авлагыг барагдуулахаар төлөвлөсөн нь ажиллах хүчний нөөцөд уялдуулан төлөвлөөгүй байна.
4. “ХААК” ТӨХХК-ийн нийт өглөгийн үлдэгдэл 226,042.5 сая төгрөг байна. Үүнээс БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй дамжуулан зээлийн үлдэгдэл 190,593.4 сая төгрөг, БНБУ-ын техникийн зээлийн үлдэгдэл 5,969.7 сая төгрөг, “Ди Би Эм лизинг” ХХК-ийн санхүүгийн зээлийн үлдэгдэл 29,489.4 сая төгрөгийн зээлийг хуваарийн дагуу төлөлт хийгдэж байна.
5. “ХААК” ТӨХХК-ийн дэмжлэгийн бус зээлийн авлагад бүртгэлтэй байгаа 3,094.1 сая төгрөгийн 63 байгууллагатай тооцоо нийлж, авлага барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
6. 2023, 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хангалтгүй биелүүлж алдагдалтай ажилласан, ХАА-г дэмжихээр олгосон нийт 174,986.5 сая төгрөгийн 8523 зээлийн 80.4 хувь буюу 140,627.8 сая төгрөгийн 8110 зээл хугацаа хэтрэлттэй байна.
7. Монголбанкны зээлийн мэдээллийн санд ХАА-г дэмжих зээлийн 65,844.8 сая төгрөгийн 654 зээлдэгчийн мэдээллийг бүртгээгүй нь зээлийн эргэн төлөлтийг графикайн дагуу төлүүлэхгүй байх, нийт зээлд эзлэх муу зээлдэгчийн хувь хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байна.

Зээлийн батлан даалтын сан

1. ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн баталсан зарим журмуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахгүйгээр үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.
2. УБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлд ЗБДС-ийн хувьцаа эзэмшигчээр Сангийн яам, Монголын Ажил олгогч эдийн нэгдсэн холбоо, Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөрийн яам /хуучин нэрээр/ бүртгэснийг шинэчлэх шаардлагатай байна.
3. ЗГ-ын 2021 оны 42 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолд заасны дагуу ЗБДС нь Хадгаламжийн даатгалын корпораци хооронд байгуулсан 2021 оны 12/02-02 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэрээ”-нд заасны дагуу санхүүжилтийн эргэн төлөлтийг хийсэн байна.
4. СЗХ-ны 2019 оны 46 дугаар “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2-т заасны дагуу ЗБДС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд 2023, 2024 онд хяналт, шалгалт хийгээгүй байна.
5. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй дамжуулан зээлийн нийт үлдэгдэл 116,035.3 сая төгрөг байна. Үүнээс 43 зээлдэгчийн 7,328.7 сая төгрөг буюу 6.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.
6. ХХААХҮЯ-ны харьяа ЗБДС нь салбарын яамны эрх асуудалд бүрэн нийцэхгүй салбарт зээлийн батлан даалт гаргаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар /Монгол Улсын Ерөнхий сайд-д:

1. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй уялдуулан бодлого арга зүйгээр хангах салбарын яамыг оновчтой тогтоож өгөх,

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц-д:

1. ЗБДС-ын үйл ажиллагаанд “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу хяналт, шалгалтын тогтмол хийх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Т.Жамбалцэрэн-д

1. ЖДҮГ-ын стратеги төлөвлөгөөг холбогдох хууль журамд нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж эрх бүхий албан тушаалтнаар батлуулах,
2. ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлтэй уялдуулан, эдийн засгийн тооцоо судалгаа хийж ерөнхий нөхцөлийг батлах, хэрэгжилтэд хяналт хийх,
3. Хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН-ийн эргэн төлөлтөд үнэлгээ хийж, эрсдэлийг тооцож, хяналт шалгалт хийх.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан-д:

1. ЖДҮХ сангаас жижиг болон дунд ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох нөхцөлийг бүрдүүлэх;
2. ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээл авахаар хүсэлт ирүүлсэн ААН-ийн төслийг тухайн жилийн ерөнхий нөхцөлд заасан салбар, чиглэлийн дагуу олгож байх;
3. *“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах (төсөл хүлээн авснаас хойш нарийвчилсан үнэлгээ хийх, сонгон шалгаруулалт хийх, гэрээ байгуулах үе шат бүрийн хугацааг тодорхой болгох);*
4. Зээлийн авлагын үлдэгдлээс 214 зээлдэгчийн 4,865.4 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авах;

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цогтсаран-д:

1. Бизнес төлөвлөгөөг бодитой төлөвлөх, төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;
2. ХАА-г дэмжих чиглэлээр олгосон зээлдэгчийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд ангилал тус бүрээр үнэн зөв, бүрэн оруулах;
3. Дэмжлэгийн бус зээлийн авлагад бүртгэлтэй байгаа 3,094.1 сая төгрөгийн 63 байгууллагатай тооцоо нийлж, авлага барагдуулах;
4. Хугацаа хэтэрсэн 8110 зээлдэгчийн 140,627.8 сая төгрөгийг эргэн төлүүлэх арга хэмжээг эрчимжүүлж төлөвлөгөө гаргаж ажиллах

ЗБДС-ийн Гүйцэтгэх захирал С.Цогтсайхан-д:

1. ЗБДС-ийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож буй журмуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулах, захиргааны хэм хэмжээний акт мөн эсэхийг тогтоолгох;
2. УБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлд ЗБДС-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг шинэчлэн бүртгүүлэх;
3. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй дамжуулан зээлийн үлдэгдлийн чанаргүй зээлийн ангилалд хамаарч буй зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах, холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх